



ДУНДГОВЬ АЙМГИЙН
САЙНЦАГААН СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2021 оны 12 сарын 07 өдөр

Дугаар А/208

Мандалговь

“Тэнүүн говийн баялаг” ХХК -ны зээлийн
хугацааг сунгах тухай


Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1.5 “д”, 29.1.6. “л”, Засгийн газрын 2016 оны 153 дугаар тогтоолын хавсралтын 3 дугаар зүйлийн 5 дахь заалт, Аж үйлдвэрийн сайдын 2016 оны 72 тоот тушаалын нэгдүгээр хавсралтын 11.2 дахь заалтууд, сумын ИТХТ-ийн 2021 оны 57 тоот тогтоолыг үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. “Сум хөгжүүлэх сан”-аас 2019 онд “Эсгий үйлдвэрлэх” зориулалтаар зээл авсан “Тэнүүн говийн баялаг” ХХК-ны үйлдвэрлэлийн байр, тоног төхөөрөмж, түүхий эд нь 2021 оны 3 дугаар сарын 14-ний өдрийн байгалийн гамшигт нэрвэгдсэн байдлыг харгалзан үзэж үндсэн зээлийн төлөлтийг 2022 оны 07 сарын 2-ны өдрөөс 2023 оны 3 дугаар сарын 3-ны өдөр хүртэл 8 сараар сунгахыг СХС-ийн нарийн бичиг ЖДҮГТХМэргэжилтэн /Ш.Бямба/, ня-бо /Н.Саранзаяа/ нарт зөвшөөрсүгэй.

2. Өнөөгийн байдлаар үүссэн зээлийн хүү, алдангыг бүрэн төлж барагдуулахыг “Тэнүүн говийн баялаг” ХХК-ны захирал Х.Нямжав, үндсэн зээлийн үлдэгдэл төлөлтийг сунгаж, нэмэлт гэрээ байгуулахыг СХС-ийн нарийн бичиг ЖДҮГТХМэргэжилтэн /Ш.Бямба/, ня-бо /Н.Саранзаяа/ нарт даалгасугай.

3. Үйлдвэрлэлийн байраа сэргээн тохижуулж зээлийг зориулалтаар ашиглан, нэмэлт гэрээний хавсралтын дагуу хугацаанд нь барагдуулахыг “Тэнүүн говийн баялаг” ХХК-ны захирал /Б.Оюунтуяа/-д үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА



С.БАТ-ОРГИЛ